

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ТОЙМ



Валют, эдийн засгийн газар

2011 оны эхний хагас жилийн гүйцэтгэл

Үндсэн дансдууд: /сая ам.доллараар/
 • Урсгал данс (1001.4)
 • Хөрөнгө ба Санхүүгийн данс 1509.7
 • Цэвэр нөөцийн өөрчлөлт (220.1)

| Үзүүлэлт | Эхний хагас жил | | Өөрчлөлт | |
|--|-----------------|----------------|---------------|---------------|
| | 2010 | 2011 | Мөнгөн дүн | Хувь |
| I. Урсгал Тэнцэл | -206,9 | -1001,4 | -794,5 | 384,0% |
| <i>А. Бараа ба үйлчилгээний худалдаа</i> | -133,9 | -850,0 | -716,1 | 534,9% |
| <i>а. Бараа (1-2)</i> | -4,1 | -330,3 | -326,2 | 7988,5% |
| 1. Экспорт Ф.О.Б. | 1308,7 | 2075,2 | 766,5 | 58,6% |
| 2. Импорт Ф.О.Б. | -1312,8 | -2405,4 | -1092,7 | 83,2% |
| <i>б. Үйлчилгээ</i> | -129,8 | -519,7 | -390,0 | 300,5% |
| 1. орлого | 186,7 | 252,3 | 65,5 | 35,1% |
| 2. зарлага | -316,5 | -772,0 | -455,5 | 143,9% |
| <i>Б. Цэвэр орлого</i> | -156,3 | -282,8 | -126,5 | 80,9% |
| <i>В. Урсгал шилжүүлэг</i> | 83,3 | 131,5 | 48,2 | 57,9% |
| <i>а. Ажилчдын гуйвуулга</i> | 60,3 | 47,1 | -13,2 | -21,9% |
| 1. Хүлээн авсан | 108,7 | 124,2 | 15,5 | 14,2% |
| 2. Шилжүүлсэн | -48,5 | -77,1 | -28,7 | 59,1% |
| <i>б. Бусад шилжүүлэг</i> | 23,0 | 84,4 | 61,4 | 266,4% |

Төлбөрийн тэнцэл 2011 оны эхний хагас жилд:

- Тайлант хугацаанд урсгал данс 1001.4 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө санхүүгийн данс 1509.7 сая ам долларын ашигтай, алдаа орхигдуулга 288.2 сая ам.доллар байснаар нийт төлбөрийн тэнцэл 220.1 сая ам.долларын ашигтай гарчээ.
- Мөн хугацаанд урсгал дансны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 4.8 дахин өсч 1001.4 сая ам.долларт хүрэхэд барааны худалдааны алдагдал 80.5 дахин өсч 330.3 сая, үйлчилгээний худалдааны алдагдал 4.0 дахин өсч 519.7 сая, цэвэр орлогын дансны алдагдал 1.8 дахин өсч 282.8 сая ам.долларт тус тус хүрсэнтэй холбоотой байна.
- Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн гадагш шилжүүлсэн орлогын хэмжээ хурдацтай өсч байна.
- Урсгал шилжүүлгийн дотогшлох цэвэр дүн 63.8 сая ам.доллар байгаа нь өмнөх оны мөн үеэс 87%-иар өсчээ.
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1827.1 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.9 дахин өссөн нь санхүүгийн дансны ашгийг 5.9 дахин нэмэгдүүлэн 1449.3 сая ам.долларт хүрэхэд нөлөөлөв.

| Үзүүлэлт | Эхний хагас жил | | Өөрчлөлт | |
|-----------------------------------|-----------------|---------------|---------------|-------------|
| | 2010 | 2011 | Мөнгөн дүн | Хувь |
| Санхүүгийн данс | 263.6 | 1449.3 | 1185.7 | 450% |
| <i>а. Шууд хөрөнгө оруулалт</i> | 620.6 | 1827.1 | 1206.5 | 194% |
| <i>б. Багцын хөрөнгө оруулалт</i> | -153.8 | 3.8 | 157.6 | -102% |
| <i>в. Бусад хөрөнгө оруулалт</i> | -203.2 | -381.5 | -178.3 | 88% |

Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс
Валют, эдийн засгийн газар

Монголбанк

Бага тойруу 3, Улаанбаатар 15160

Утас: 976-11-323243, 318304, 327088

bor@mongolbank.mn

УРСГАЛ ДАНС

- Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2011 оны эхний хагас жилийн байдлаар 14.3 хувьд хүрсэн хэдий ч, урсгал дансны алдагдал ДНБ-ний 34%-д хүрч, өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн дээд цэгтээ хүрчээ. Үүнд бараа болон үйлчилгээний алдагдал өмнөх жилүүдтэй харьцуулахад хурдацтай өсч байгаа нь голлон нөлөөлж байна. Тухайлбал:
- Барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 70.5 хувиар өсч 4,480.6 сая ам.долларт хүрчээ. Энэ нь Монгол улсын экспортын бараа бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ болон биет хэмжээ өссөн хэдий ч уул уурхайн төслүүдийн хэрэгжилттэй уялдан хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт, дэлхийн зах зээл дэх нефтийн үнийн өсөлт, мөн түүний нийлүүлэлтийн хэлбэлзлээс шалтгаалж импортын хэмжээ экспорттоос 23.5 пунктээр илүү хурдацтай өсч, барааны гадаад худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 80.5 дахин өсчээ.
- Үйлчилгээний худалдааны орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 35.1 хувиар өсч 252.3 сая ам.долларт хүрсэн боловч зарлага нь илүү хурдацтай буюу 143.9 хувиар өсч 772.0 сая ам.доллар болсноор үйлчилгээний худалдааны алдагдал 4.4 дахин нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Үйлчилгээний худалдааны алдагдал ийнхүү өсөхөд импортын барааны тээвэрлэлтийн зардал өнгөрсөн оны мөн үеэс 4.9 дахин өсч 406.4 сая ам.долларт, аялал жуулчлалын зардал 2.0 дахин өсч 101.4 сая ам.долларт хүрсэн нь голлон нөлөөлсөн байна.
- Монгол Улсын Засгийн газар, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж /ААН/, иргэд нь эдийн засгийн харьяат бусаас авсан гадаад зээл, өрийн бичиг болон харилцах, хадгаламжийн хүүгийн төлбөрт 52.0 сая ам.долларыг төлж, дахин хөрөнгө оруулалтын орлогын дансанд 155.1 сая ам.долларын зарлагын бичилт хийгдсэнээр цэвэр орлогын данс 282.8 сая ам.долларын алдагдалтай гарав.
- Гадаадын улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэдээс хүлээн авсан гуйвуулгын дүн өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар өсч, харин гадаадын улс орнууд руу шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ 59.1 хувиар өссөн нь ажилчдын цэвэр гуйвуулгын дүн 21.9 хувиар буурахад нөлөөлжээ. Энэ нь гадаад руу шилжүүлсэн гуйвуулгын дийлэнх хувийг эзэлдэг АНУ, БНХАУ-руу шилжүүлсэн гуйвуулгын хэмжээ өмнөх оны мөн үеэс харгалзан 78.0, 102.0 хувиар нэмэгдсэнээр шалтгаалсан байна.

ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ДАНС

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 1827.1 сая ам.доллар байгаа нь манай улсын ашигт малтмал, уул уурхайн салбарт орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт 1587.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.9 дахин буюу 1181.2 сая ам.доллараар, хямралын өмнөх 2008 оны мөн үетэй харьцуулахад 8.4 дахин буюу 1399.6 сая ам.доллараар өссөнтэй холбоотой.
- 2011 оны 6 дугаар сарын 8-нд арилжаалагдсан Засгийн газрын бондоос эдийн засгийн харьяат бус 5.9 сая ам.долларыг худалдаж авсан нь Монгол улс дахь багцын (санхүүгийн) хөрөнгө оруулалтын хэмжээг цэвэр дүнгээр 3.8 сая ам.долларын эерэг үлдэгдэлтэй гарахад нөлөөлжээ.
- Эдийн засгийн харьяат ААН-үүд шууд хөрөнгө оруулагчдаас 1177.31 сая ам.долларын эргэн төлөгдөх нөхцөлтэй эх үүсвэр, санхүүжилт (зээл)-ийг авч ашигласан нь өнгөрсөн оны мөн үеэс 8.3 дахин өссөн үзүүлэлт юм.
- Монгол Улсын Засгийн газрын шугамаар болон түүний баталгаатайгаар хандивлагч орон болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас 2011 оны эхний хагас жилийн байдлаар 43.2 сая ам.доллартай тэнцэх зээл авч, 28.9 сая ам.долларын үндсэн төлбөрийг төлжээ.
- Банк болон банк бус хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд нь харьяат бусаас 216.4 сая ам.долларын урт, 253.4 сая ам.долларын богино хугацааны зээл авч ашиглан, 292.5 сая ам.долларын эргэн төлөлтийг гүйцэтгэсэнээр цэвэр дүнгээр 177.3 сая ам.долларын орох урсгалтай байв.







ГАДААД ВАЛЮТЫН ЦЭВЭР АЛБАН НӨӨЦ

- Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2011 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар 2,339.5 сая ам.долларт хүрчээ. Энэ нь 2010 оны импортын гүйцэтгэлээр 5.9 сарын, 2011 оны импортын төсөөллөөр 5.5 сарын импортын хэрэгцээг хангах түвшинд байна.


АЛДАА БОЛОН ОРХИГДУУЛГА

- Тайлант хугацаанд алдаа ба орхигдуулга үзүүлэлт абсолют дүнгээр 288.2 сая ам.доллар гарсан нь 5 дугаар сард арилжааны банкууд гадаадын банк санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламжаа 231.4 сая ам.доллараар огцом бууруулсантай холбоотой.





Хавсралт 1. Урсгал дансны хүснэгт, график



| Үзүүлэлт | 2-р улирал | | Өөрчлөлт | |
|--|------------|-----------|-----------|--------|
| | 2010 | 2011 | дүн | Хувь |
| Жуулчлалын салбарын нийт орлого (сая ам.доллараар) | 51,6 | 55,7 | 4,1 | 8,0% |
| Гадаадын жуулчдын тоо | 76 741,0 | 83 147,0 | 6 406,0 | 8,3% |
| Жуулчлалын салбарын нийт зардал (сая ам.доллараар) | 49,5 | 101,4 | 51,9 | 105,0% |
| Гадаадад жуулчилсан Монгол иргэдийн тоо | 100 567,5 | 209 318,3 | 108 750,8 | 108,1% |
| Жуулчлалын цэвэр орлого (сая ам.доллараар) | 2,1 | (45,7) | (47,8) | 21,5x |



Хавсралт 2. Санхүүгийн дансны хүснэгт, график



Хавсралт 3. Төлбөрийн тэнцэлд тохируулга хийх

- Төлбөрийн тэнцлийн жилийн дүн эцэслэн гарах хүртэлх хугацаанд шаардлагатай тохиолдолд улирлын нэгтгэлд өөрчлөлт хийдэг.
- Аль улирлын өөрчлөлт болохыг тодорхойлох боломжгүй үед өөрчлөлтийг 4 дүгээр улиралд оруулна.
- Гадаад худалдааны гаалийн жилийн статистикт өөрчлөлт орохтой холбогдон урьдчилсан байдлаар нэгтгэн гаргасан төлбөрийн тэнцлийн урсгал дансны гүйлгээний дүн өөрчлөгддөг.
- Урьдчилсан байдлаар гаргасан төлбөрийн тэнцэлд холбогдох өөрчлөлтийг тусгаж эцэслэн 2 дугаар улиралд багтаан гаргадаг.

Хавсралт 3.1 Төлбөрийн тэнцлийн хураангуй (сая ам.доллараар)

| Үзүүлэлт | Эхний хагас жил | | Өөрчлөлт | |
|--|-----------------|-----------------|----------------|---------------|
| | 2010 | 2011 | Мөнгөн дүн | Хувь |
| I. Урсгал Тэнцэл (А+В+С) | -206.9 | -1 001.4 | -794.5 | 384% |
| А. Бараа ба үйлчилгээний худалдаа (1+2) | -133.9 | -850.0 | -716.1 | 535% |
| 1. Бараа | -4.1 | -330.3 | -326.2 | 7989% |
| 1.1 Ерөнхий эд бараа | -101.4 | -385.0 | -283.6 | 280% |
| Экспорт Ф.О.Б. (Кредит) | 1 200.5 | 2 009.0 | 808.5 | 67% |
| Үүнээс: Зэсийн баяжмал | 383.7 | 503.0 | 119.3 | 31% |
| Импорт Ф.О.Б. (Дебит) | -1 301.9 | -2 394.0 | -1 092.1 | 84% |
| Үүнээс: Нефтийн бүтээгдэхүүн | -278.5 | -413.4 | | |
| Хүнсний бүтээгдэхүүн | -151.5 | -164.7 | | |
| 1.2 Мөнгөжөөгүй алт | 107.7 | 65.7 | -42.0 | -39% |
| Кредит | 107.7 | 65.7 | -42.0 | -39% |
| Дебит | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 1.3 Бусад | -10.4 | -10.9 | | |
| Кредит | 0.5 | 0.5 | | |
| Дебит | -10.9 | -11.4 | | |
| 2. Үйлчилгээ | -129.8 | -519.7 | -390.0 | 300% |
| 2.1 Тээвэр | -43.8 | -354.8 | -311.0 | 710% |
| Кредит | 69.7 | 99.1 | 29.5 | 42% |
| Дебит | -113.4 | -454.0 | -340.5 | 300% |
| 2.2 Аялал | -14.9 | -76.5 | -61.5 | 412% |
| Кредит | 92.1 | 98.9 | 6.8 | 7% |
| Дебит | -107.0 | -175.3 | -68.3 | 64% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -71.1 | -88.5 | -17.4 | 24% |
| Кредит | 25.0 | 54.3 | 29.2 | 117% |
| Дебит | -96.1 | -142.7 | -46.6 | 49% |
| В. Орлого (1+2) | -156.3 | -282.8 | -126.5 | 81% |
| 1. Ажиллагсдын цалин хөлс | -5.7 | -48.7 | -43.0 | 752% |
| Кредит | 7.1 | 11.3 | 4.2 | |
| Дебит | -12.8 | -60.1 | -47.3 | 369% |
| 2. Хөрөнгө оруулалтын орлого | -150.6 | -234.1 | -83.5 | 55% |
| Кредит | 3.5 | 7.8 | 4.4 | 127% |
| Дебит | -154.1 | -242.0 | -87.9 | 57% |
| С. Урсгал шилжүүлэг (нэвэр) | 83.3 | 131.5 | 48.2 | 58% |
| Кредит | 133.5 | 216.9 | 83.4 | 62% |
| Дебит | -50.2 | -85.4 | -35.2 | 70% |
| Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга | 60.3 | 47.1 | -13.2 | -22% |
| Кредит | 108.7 | 124.2 | 15.5 | 14% |
| Дебит | -48.5 | -77.1 | -28.7 | 59% |
| II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл (А+В) | 321.2 | 1 509.7 | 1 188.6 | 370% |
| А. Хөрөнгийн данс | 57.5 | 60.4 | 2.8 | |
| Кредит | 57.6 | 60.5 | 2.9 | |
| Дебит | -0.1 | -0.1 | 0.0 | |
| В. Санхүүгийн данс (1+2+3+4) | 263.6 | 1 449.3 | 1 185.7 | 450% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 620.6 | 1 827.1 | 1 206.4 | 194% |
| 1.1 Гадагш хийсэн | -14.9 | -34.6 | -19.7 | 132% |
| 1.1.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө | -14.4 | -34.0 | -19.6 | 136% |
| 1.1.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 1.1.3 Бусад хөрөнгө | -0.5 | -0.6 | -0.2 | 34% |
| 1.2 Монголд орсон | 635.5 | 1 861.7 | 1 226.1 | 193% |
| 1.2.1 Хувь нийлүүлсэн хөрөнгө | 476.4 | 887.7 | 411.3 | 86% |
| 1.2.2 Орлогын дахин хөрөнгө оруулалт | 35.5 | 155.1 | 119.7 | |
| 1.2.3 Бусад хөрөнгө | 123.6 | 818.8 | 695.2 | 562% |
| 2. Багцын (санхүүгийн) хөрөнгө оруулалт | -153.8 | 3.8 | 157.6 | -102% |
| 2.1 Актив | -37.0 | -15.4 | 21.6 | -58% |
| 2.1.1 Хөрөнгийн хувицаа | -5.1 | 4.2 | 9.3 | -183% |
| 2.1.2 Өрийн бичиг | -31.9 | -19.6 | 12.3 | -39% |
| 2.1.2.1 Бонд үнэт цаас | 2.1 | 0.0 | -2.1 | 0% |
| 2.1.2.2 Мөнгөний захын хэрэгсэл | -34.0 | -19.5 | 14.4 | -42% |
| 2.2 Пассив | -116.9 | 19.2 | 136.0 | -116% |
| 2.2.1 Хөрөнгийн хувицаа | -4.9 | 10.2 | 15.1 | -309% |
| 2.2.2 Өрийн бичиг | -112.0 | 8.9 | 120.9 | |
| 2.2.2.1 Бонд үнэт цаас | -112.0 | 8.9 | 120.9 | -108% |
| 2.2.2.2 Мөнгөний захын хэрэгсэл | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (нэвэр) | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 3.1 Актив | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 3.2 Пассив | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | -203.2 | -381.5 | -178.3 | 88% |
| 4.1 Актив | -247.0 | -605.7 | -358.7 | 145% |
| 4.1.1 Худалдааны зээл | 7.6 | -110.6 | -118.1 | -1557% |
| 4.1.2 Зээл | 0.2 | -12.4 | -12.6 | -5764% |
| 4.1.3 Бэлэн мөнгө ба харилцах | -254.8 | -482.7 | -227.9 | 89% |
| 4.1.4 Бусад актив | 0.0 | 0.0 | 0.0 | 0% |
| 4.2 Пассив | 43.8 | 224.2 | 180.4 | 411% |
| 4.2.1 Худалдааны зээл | -0.5 | 21.6 | 22.1 | -4717% |
| 4.2.2 Зээл | 83.4 | 215.8 | 132.4 | 159% |
| 4.2.2.1 Төв банк | -0.7 | -3.1 | -2.4 | |
| 4.2.2.2 Засгийн газар | -4.9 | -18.4 | -13.5 | 278% |
| 4.2.2.3 Банк | 32.5 | 50.2 | 17.6 | 54% |
| 4.2.2.4 Бусад сектор | 56.5 | 187.1 | 130.6 | 231% |
| 4.2.3 Бэлэн мөнгө ба харилцах | -39.1 | -15.4 | 23.7 | -61% |
| 4.2.4 Бусад пассив | 0.0 | 2.2 | 2.2 | |
| III. Алдаа болон орхигдуулга | 11.8 | -288.2 | -300.0 | -2539% |
| <i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн (I+II+III)</i> | <i>126.1</i> | <i>220.1</i> | <i>94.1</i> | <i>75%</i> |
| IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт (1+2) | -126.1 | -220.1 | -94.1 | 75% |
| 1. Актив | -146.7 | -222.1 | -75.4 | |
| 1.1 Мөнгөжсөн алт | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 1.2 Зээлжих тусгай эрх | 5.4 | -1.3 | -6.8 | |
| 1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 | |
| 1.4 Бэлэн валют ба харилцах | -132.4 | -246.2 | -113.8 | |
| 1.5 Бусад нөөц актив | -19.7 | 25.5 | 45.2 | |
| 2. Пассив | 20.6 | 1.9 | -18.7 | |
| 2.1 ОУВС-ийн зээл | 20.6 | 1.9 | -18.7 | |
| 2.2 Онцгой санхүүжилт | 0.0 | 0.0 | 0.0 | |